

БАТЛАВ:



МХПН-ИЙН ТЭРГҮҮН М. ЭНХБОЛД  
2024 ОНЫ 8-Р САРЫН 9

**МОНГОЛЫН ХАНГЛАЙДИНГ, ПАРАГЛАЙДИНГИЙН НИЙГЭМЛЭГ  
ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЖУРАМ**

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Энэхүү журмаар “Монголын Ханглайдинг, Параглайдингийн Нийгэмлэг” /цаашид МХПН гэх-/ийн гишүүн элсүүлэх, тэдгээрийн ангилал, гишүүний эрх, үүрэг, гишүүний татвар, хандив болон гишүүдийн үйл ажиллагаатай холбоотой бусад харилцааг зохицуулна.
- 1.2. МХПН-ийн гишүүнчлэл нь гишүүн байгууллага, хувь хүн гэсэн хоёр ангилалтай байна.

**ХОЁР. ГИШҮҮН**

- 2.1. МХПН нь параглайдингийн спортоор хичээллэдэг, сонирхдог, дэмждэг хувь хүмүүсийн нэгдэн нийлж байгуулсан клубийг гишүүнээр элсүүлнэ. Клубийн үндсэн үйл ажиллагаа нь параглайдингийн чөлөөт нислэг хийх, тэмцээнд бэлдэх, гишүүдээ хөгжүүлэхэд чиглэгдсэн байна. Харин сургалт, тандем нислэгийн үйл ажиллагаа эрхлэх бол МХПН-ээс тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр хэрэгжүүлнэ.
- 2.2. МХПН нь параглайдингийн спортоор хичээллэдэг, сонирхдог, дэмждэг хувь хүнийг гишүүнээр элсүүлнэ. Хувь хүнд сургалт, тандем нислэгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг МХПН-ээс олгохгүй.
- 2.3. Гишүүн нь МХПН-ийн зорилго, үйл ажиллагааг дэмжин ажиллана.

**ГУРАВ. ГИШҮҮНИЙГ ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ БОЛОН ГИШҮҮНИЙ БҮРТГЭЛ**

МХПН нь гишүүнийг элсүүлэхдээ дараах журмаар элсүүлнэ.

- 3.1. Энэхүү журмын 2.1.-т заасан клубийг МХПН-т ирүүлсэн хүсэлт /албан бичгээр/, эрх бүхий байгууллагын шийдвэр, тогтоол, байгууллагын гэрчилгээний хуулбар, гишүүний татвар төлсөн баримт / Төрийн банк дахь МХПНийгэмлэг 385000082949 тоот дансанд/-ыг хүлээн авч ажлын 5 хоногт багтаан шийдвэрлэнэ.
- 3.2. Энэхүү журмын 2.2.-т заасан хувь хүнийг МХПН-т ирүүлсэн өргөдөл, анкет, гишүүний татвар төлсөн баримт / Төрийн банк дахь МХПНийгэмлэг 385000082949 тоот дансанд/-ыг хүлээн авч ажлын 7 хоногт багтаан шийдвэрлэнэ.

**ДӨРӨВ. ГИШҮҮН БАЙГУУЛЛАГЫН ЭРХ**

МХПН-ийн гишүүн байгууллага дараах нийтлэг эрх эдэлнэ. Үүнд:

- 4.1. МХПН-ийн Удирдах зөвлөлд гишүүдээ нэр дэвшүүлэх;
- 4.2. Клуб МХПН-ийн гишүүнээр элссэн өдрөөс эхлэн клубийн төлөөлөл нь МХПН-ийн Удирдах зөвлөлийн гишүүнд тооцогдон, үйл ажиллагаанд оролцох;
- 4.3. МХПН, MACX, ДАСХ (FAI)-ны үйл ажиллагаа, дүрэм журам, түүнд орсон өөрчлөлт болон дотоод, гадаадад болох тэмцээн уралдаан, сургалт, семинар, бусад арга хэмжээний тухай дэлгэрэнгүй мэдээллийг цаг алдалгүй авах;
- 4.4. МХПН-ийн Параглайдерын нисгэгчийн түвшин тогтоох үнэлгээний системийн дагуу клубийн гишүүдийнхээ ур чадварын түвшинг тогтоолгон, гишүүддээ үндэсний нисгэгчийн үнэмлэх авах, сунгуулах хүсэлтийг МХПН-т уламжлах;
- 4.5. МХПН-ээр дамжуулан тамирчдынхаа ДАСХ (FAI)-ны спортын лицензийг жил бүр сунгуулах, CIVL ID болон IPP Card авахад дэмжлэг хүсэх;
- 4.6. Гадаад, дотоодод зохион байгуулагдах төрөл бүрийн уралдаан тэмцээн, арга хэмжээнд давуу эрхтэйгээр хамрагдах, бүртгэл мэдүүлэг бөглөх, явуулах болон бусад харилцаа холбоо, ивээн тэтгэгч олох зэрэг асуудал дээр МХПН-ийн туслалцаа дэмжлэгийг авах;
- 4.7. МХПН-ийн хамтрагч, ивээн тэтгэгч байгууллагуудаас /Хамтын ажиллагааны гэрээ, санамж бичгийн дагуу/ далавч хэрэгсэл худалдан авах, сургалтанд хамрагдахад хөнгөлөлт эдлэх, реклам, зар сурталчилгаанд оролцох, гишүүдээ хамруулах;
- 4.8. Шинээр ажил санаачлан түүнийгээ хэрэгжүүлэх, өөрийн зохион байгуулах арга хэмжээндээ МХПН-ээс мэргэжлийн туслалцаа авах;

#### ТАВ. ГИШҮҮН БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ

МХПН-ийн гишүүн байгууллага нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- 5.1. МХПН-ийн дүрэм, Удирдах зөвлөлөөс баталсан журмуудыг чанд сахиж, ДАСХ (FAI), MACX болон параглайдингийн спортын олон улсын стандарт, хэм хэмжээ, дүрмийг мөрдлөг болгон биелүүлэх;
- 5.2. МХПН-ийн Параглайдерын нисгэгчийн түвшин тогтоох үнэлгээний системийн дагуу клубын гишүүдийнхээ ур чадварын түвшинг тогтоолгон, үндэсний нисгэгчийн үнэмлэх авах, зөвхөн нисгэгчийн үнэмлэхтэй гишүүдийг чөлөөт нислэг болон аливаа арга хэмжээнд оролцуулах;
- 5.3. МХПН-ээс зохион байгуулж байгаа тэмцээн уралдаан, аливаа арга хэмжээнүүдэд идэвхи санаачлагатай оролцох;
- 5.4. Гадаад, дотоодын тэмцээнд оролцоход шаардлагатай мэдүүлэг болон бусад бичиг баримтыг тогтоосон хугацаанд үнэн зөв гаргаж, МХПН-т өгөх;

- 5.5. Гишүүд нь МХПН-ийн зөвшөөрөлгүйгээр МХПН-ийг төлөөлөн гадаадын аль нэг байгууллага, компани, ДАСХ (FAI), МАСХ болон холбогдох бусад олон улс, тив, дэлхийн байгууллагуудад хандах, гэрээ, хэлцэл хийхгүй байх;
- 5.6. МХПН-ийн Удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэр, хүлээж авсан үүргээ хугацаанд нь чанартай гүйцэтгэх, хэрэв боломжгүй гэж үзвэл тайлбараа бичгээр гаргах;
- 5.7. Олон улс, тив, дэлхийн тэмцээнд Монгол Улсын иэрийн өмнөөс оролцох багийн бүрэлдэхүүнд орсон тамирчид, дасгалжуулагчид, албаны хүмүүс нь зохион байгуулагдаж буй тэмцэний бэлтгэл, нээлт, хаалтын ажиллагаа, шагнал гардуулах ёслол, хэвлэлийн бага хурал болон бусад арга хэмжээнд зөвхөн МХПН-ийн УЗ-өөс баталсан өнгө, загварын хувцастай оролцох, МХПН-ийн лого, туг, тэмдгийг хэрэглэх;
- 5.8. Гишүүний татвараа тогтоосон хугацаанд төлөх;

#### **ЗУРГАА. ГИШҮҮН ХУВЬ ХҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ**

- 6.1. МХПН-ийн гишүүн хувь хүн нь энэ журмын Бүлэг 4-т заасан гишүүн клубийн гишүүдэд хамаарах бүх эрхийг эдэлж, Бүлэг 5-д заасан гишүүн клубийн гишүүдэд хамаарах бүх үүргийг хүлээнэ.
- 6.2. Гишүүн хувь хүн жилийн татвараа төлсний дараа Үндэсний нисгэгчийн үнэмлэх болон спортын лиценз шинээр авах, сунгуулах эрх нь үүснэ.

#### **ДОЛОО. ГИШҮҮНИЙ ТАТВАР, ХАНДИВ**

- 7.1. Гишүүн байгууллага нэг жилд 5 сая (таван сая) төгрөгийн татвар төлнө.
- 7.2. Гишүүн хувь хүн нэг жилд 1.5 сая (нэг сая таван зуун мянга) төгрөгийн татвар төлнө.
- 7.3. Жилийн дундуур гишүүнээр элссэн тохиолдолд гишүүний татварыг жилийн үлдэж буй саруудад хувь тэнцүүлсэн байдлаар төлнө.
- 7.4. Гишүүний жилийн татварыг жилд 4 хуваан, улирал бүрийн эхний сарын 10-ны дотор төлж барагдуулна.
- 7.5. Гишүүний татвараа хугацаанд нь төлөөгүй тохиолдолд хоцорсон сар бүрт 0.5%-ийн алданги нэмж төлнө.
- 7.6. МХПН-т элссэн клуб нь тухайн жилдээ үйл ажиллагаа явуулаагүй гэх шалтгаанаар татвараас чөлөөлөгдөхгүй бөгөөд дахин элсэх хүсэлт гаргавал өмнөх хугацааны татварыг нөхөн төлнө.
- 7.7. Гишүүн нь сайн дурын үндсэн дээр МХПН-ээс зохион байгуулж буй арга хэмжээг ивээн тэтгэхэд зориулж хандив өгч болно.

#### **НАЙМ. ГИШҮҮНЭЭС ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ЧӨЛӨӨЛӨХ**

Гишүүнээс чөлөөлөх, эрхийг түдгэлзүүлэх тухай шийдвэрийг Удирдах зөвлөлийн хурлаас гаргана. Дараах тохиолдолд гишүүнээс чөлөөлөх, эсвэл эрхийг түдгэлзүүлнэ. Үүнд:

- 8.1. Гишүүний татварыг тус журамд заасан хугацаанд төлөөгүй;
- 8.2. МХПН-ээс зохион байгуулсан арга хэмжээнд 2 болон түүнээс дээш удаа оролцогүй бол;
- 8.3. МХПН-ийн зорилго, үйл ажиллагааны талаар үнэнд нийцэхгүй мэдээлэл тараах, гүтгэх, нэр төрийг гутаах, эсрэг үйл ажиллагаа явуулсан бол;
- 8.4. Удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэр, хүлээж авсан үүргээ удаа дараа биелүүлээгүй бол  
гишүүн клубийн гишүүд болон хувь гишүүний спортын лицензийг түр хугацаагаар хааж, гадаад, дотоодын тэмцээн, уралдаанд оролцох, сургалт, тандем нислэгийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлнэ.
- 8.5. Гишүүн өөрөө гишүүнчлэлээс гарах хүсэлтээ бичгээр гаргасан бол чөлөөлнө.

#### ЕС. БУСАД

- 9.1. Энэхүү журам нь 2024 оны 8-р сарын 10-наас хүчин төгөлдөр болж, хэрэгжиж эхэлнэ.
- 9.2. Гишүүнчлэлийн журамд Удирдах зөвлөлийн шийдвэрээр иэмэлт өөрчлөлт оруулж болно.
- 9.3. Гишүүд иэмэлт өөрчлөлт оруулах санал ирүүлэх боломжтой.

#### БАТАЛСАН:

МХПН-ийн Удирдах Зөвлөлийн гишүүд  
М. Энхболд \_\_\_\_\_  
П. Болд \_\_\_\_\_  
А. Батдаваа \_\_\_\_\_  
Ч. Туул \_\_\_\_\_  
М. Энхбаяр \_\_\_\_\_  
Н. Мөнхбаяр \_\_\_\_\_  
С. Энхмандах \_\_\_\_\_  
А. Энхзориг \_\_\_\_\_  
Б. Болормаа \_\_\_\_\_